


**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ**

**Санамж:**

**a. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.**

**b. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.**

1. Дараах түүхийн дурсгалыг орших газар нутагтай нь тохируулна уу? (2 оноо)
- |                        |                                   |
|------------------------|-----------------------------------|
| 1. Цагаан агуй         | a. Хэнтий аймгийн Батширээт сум   |
| 2. Рашаан хад          | b. Баянхонгор аймгийн Баянлиг сум |
| 3. Хойд Цэнхэрийн агуй | c. Ховд аймгийн Манхан сум        |
| 4. Чандманий соёл      | d. Увс аймгийн Улаангом сум       |
| A. 1-b, 2-a, 3-c, 4-d  | B. 1-a, 2-d, 3-b, 4-c             |
| C. 1-b, 2-a, 3-d, 4-c  | D. 1-a, 2-b, 3-c, 4-d             |
|                        | E. 1-d, 2-c, 3-b, 4-a             |
2. Дараах дурсгалуудын аль нь Палеолитын доод шатанд хамаарахгүй вэ? (1 оноо)
- A. Дундговь аймгийн Гурван сайхан сумын нутагт орших Ярх уул  
B. Өмнөговь аймгийн Булган сумын Цахиуртын хөндий  
C. Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутагт орших Цагаан агуйн суурин  
D. Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уул  
E. Ховд аймгийн Манхан сумын Хойд Цэнхэрийн агуй
3. Неолитийн үеийн хүмүүсийн амьдрал, аж ахуйд гарсан гол өөрчлөлт болох “Неолитийн хувьсгал” гэж ямар өөрчлөлтийг хэлдэг вэ? (2 оноо)
- A. Уур амьсгалд өөрчлөлт бий болж эрс тэс ширүүн уур амьсгалтай болсон  
B. Байгалийн бүтээгдэхүүнийг бэлнээр нь хэрэглэхээ больж үйлдвэрлэх болсон  
C. Галыг хэрэглэх болсноор уураг тархи нь илүү хөгжиж чадсан  
D. Нум сум зохион бүтээсэн тул амьжиргааны байдал нь эрс дээшилсэн  
E. Эцгийн эрхт байгуулалд шилжин эрчүүд нийгэмд илүү нөлөөтэй болсон
4. Чулуун зэвсгийн үеийн хүмүүс “Чулуун самбар, нухуур”-ыг ямар зориулалтаар хэрэглэдэг байсан бэ? (2 оноо)
- |   |                                   |
|---|-----------------------------------|
| A. Ургамалын үр үндэс түүх зориулалтаар | B. Амьтны арьс элдэх зориулалтаар |
| C. Тариа цайруулах зориулалтаар         | D. Гоёл чимэглэлийн зориулалтаар  |
| E. Шүтлэг бишрэлийн зориулалтаар        |                                   |
5. Монголын түүхэн дэх “Энеолитийн үе” гэдэг нь дараах ойлголтуудын алинд нь хамаарах вэ? (1 оноо)
- |                              |                            |
|------------------------------|----------------------------|
| A. Хуучин чулуун зэвсгийн үе | B. Дунд чулуун зэвсгийн үе |
| C. Шинэ чулуун зэвсгийн үе   | D. Зэс чулуун зэвсгийн үе  |
|                              | E. Хүрэл зэвсгийн үе       |
6. Монгол нутаг дахь хадны зургийн дурсгалыг холбогдох үетэй нь тохируул. (2 оноо)
- |                                  |                                       |
|----------------------------------|---------------------------------------|
| 1. Ямаан усны хадны зураг        | a. Чулуун зэвсгийн үеийн хадны зураг  |
| 2. Баянлигийн хадны зураг        | b. Хүрэл зэвсгийн үеийн сийлмэл зураг |
| 3. Их тэнгэрийн амны хадны зураг | c. Сэлэнгийн зосон зураг              |
| 4. Чандмань хар үзүүрийн зураг   | d. Эртний улсуудын үе                 |
| A. 1- a, 2- b, 3- c, 4- d        | B. 1- b, 2- a, 3- d, 4- c             |
| C. 1- d, 2- b, 3- c, 4- a        | D. 1- b, 2- a, 3- c, 4- d             |
|                                  | E. 1- b, 2- c, 3- a, 4- d             |
7. Хүннү улсын түүхэнд холбогдох хот суурингийн дурсгал аль нь вэ? (1 оноо)
- |                 |                              |
|-----------------|------------------------------|
| A. Хархорум хот | B. Чинтолгойн балгас         |
| C. Хөх хот      | D. Ордубалык хот             |
|                 | E. Гуа дов, Лүн хот (Лүнтэн) |
8. Сяньби улс хэдэн онд задарч, Сяньби, Ухуань, Муюн, Тоба зэрэг аймаг улс болсон бэ? (1 оноо)
- |          |           |           |           |           |
|----------|-----------|-----------|-----------|-----------|
| A. НТ 93 | B. НТ 141 | C. НТ 156 | D. НТ 181 | E. НТ 235 |
|----------|-----------|-----------|-----------|-----------|

9. Сяньби нарын “Тоног авах ёс” хэмээх ойлголтонд аль нь багтах вэ? (2 оноо)  
 А. Толгойн үсээ хусах  
 В. Толгойн урд хэсгийн үсийг хусах  
 С. Дайсныхаа толгойн оройн хуйхыг өвчин авдаг  
 D. Дайсныхаа толгойн гавлын ясаар нь аяга хийх  
 E. Дайсныхаа толгойг авч хатаан хадгалах
10. Жужан (Нирун) улс мөхсөний хойно харьяат ард олон нь хэд хэдэн хэсэгт хуваагдсан гэвэл хамааралгүй нь аль нь вэ? (1 оноо)  
 А. Бослого гаргасан Түрэгүүдэд захирагдсан  
 B. Эргүнэ хун хэмээх газар зайлан суусан  
 C. Европт нүүж Гунну хэмээгдсэн  
 D. Вэй улсад дагаар орсон  
 E. Европт нүүж Авар хэмээгдсэн
11. Жужан улс мөхсөний дараа Нукуз, Хиан тэргүүтэй овог аймгууд очиж нутагласан “Эргүнэ хун” хэмээх газар хаана байдаг хэмээн олонхи эрдэмтэд үздэг вэ? (2 оноо)  
 А. Байгаль далайн баруун бие  
 B. Хөвсгөл нуурын баруун бие  
 C. Бурхан халдун уул, Онон гол орчим  
 D. Эргүнэ мөрөн орчмын газар нутаг  
 E. Алтайн нурууны өмнөд бие
12. Түрэгүүдэд захирагдахыг үл хүсч Өрнө зүг нүүсэн нэгэн хэсэг Жужан (Нирун) нар 558 оны үеэс Европын сударт хэн гэж тэмдэглэгдэх болсон бэ? (1 оноо)  
 А. Хүннү  
 B. Гунну  
 C. Бербер  
 D. Авар  
 E. Мажар
13. Монгол нутагт эрхшээн өөрийн төрт улсаа байгуулан, оршин тогтнож байсан Түрэгүүдийн өвөг дээдэс хаана нутаглан суудаг байсан бэ? (1 оноо)  
 А. Долоон ус  
 B. Алтайн уул  
 C. Тэнгэр уул  
 D. Енисей мөрөн  
 E. Байгаль нуур
14. Энэхүү зураг дээрх дурсгал хэдий үед холбогдох, хаана байдаг түүхийн дурсгал вэ? (2 оноо)  
 А. Архангай аймгийн Хашаат сумын нутаг Күлтегиний гэрэлт хөшөө  
 B. Увс аймгийн Орон нутаг судлах музейд буй Долоодойн гэрэлт хөшөө  
 C. Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг Тоньюкүкийн гэрэлт хөшөө  
 D. Булган аймгийн Сайхан сумын нутаг Моюунчурын гэрэлт хөшөө  
 E. Дорнод аймгийн Халх гол сумын нутаг Шонх таван толгойн хөшөө
- 
15. 840 онд Уйгурын цэргийн жанжин ..... Кыргызын Ажо хаантай хавсран Уйгурын нийслэл Ордубалык хотыг эзлэн авсан нь Уйгур улс мөхөх үндэс нь болсон гэвэл энэ жанжны нэр хэн бэ? (2 оноо)  
 А. Алп Күтүлүг  
 B. Кюлүг Их Тархан  
 C. Кюлүг Бага Тархан  
 D. Яглакар Панлей Тегин  
 E. Яглакар Инал
16. “Монголын нууц товчоо”-нд Хаад, Удуйд, Увас гэсэн гурван Мэргэд гарах бөгөөд, Хаад мэргэдийг Хаатай Дармала, Увас мэргэдийг Дайр Үсүн захирч байсан гэвэл үлдсэн Удуйд мэргэдийг хэн захирч байсан бэ? (1 оноо)  
 А. Чилгэр бөх  
 B. Их Чилэдү  
 C. Дайр үсүн  
 D. Тогтоо бэх  
 E. Үсүн өвгөн
17. 1225 оны үед холбогдох, одоогоор мэдэгдээд байгаа, монгол бичгээр бичсэн хамгийн анхны бичгийн дурсгал аль нь вэ? (1 оноо)  
 А. Гүегийн тамганы бичиг  
 B. Мөнх хааны гэрэлт хөшөө  
 C. “Монголын нууц товчоо”  
 D. “Цагаан түүх”  
 E. Чингисийн чулууны бичиг

18. “Монголын нууц товчоо”-нд өгүүлснээр, Өгөдэй хаан “... Бор дарсанд орсон минь нэг буруу болов. Хоёрт Отчигин авгын харьяатаас эхнэр авсан нь буруу болов...” хэмээн хэлсэн байх бөгөөд тэгвэл үлдсэн хоёр муу үйл аль нь вэ? (2 оноо)
- A. 1. Даргач тамгач нарыг суулгасан, 2. Өртөө улааг байгуулсан  
 B. 1. Доголхуг далдаас хардсан, 2. Алтан улсыг эзэлсэн  
 C. 1. Доголхуг далдаас хардсан, 2. Бор гөрөөсийг хашаалсан  
 D. 1. Худаг усыг гаргасан, 2. Бор гөрөөсийг хашаалсан  
 E. 1. Алтан улсыг эзэлсэн, 2. Даргач тамгач нарыг суулгасан
19. “Монголын нууц товчоо”-ны төгсгөлд, “... Их хуралдаан болж, хулгана жилийн хуран сард ..... хоёрын завсар хаан орд бууж байхад бичиж төгсгөв.” хэмээн гардаг. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоно уу? (2 оноо)
- A. Хэрлэний Хөдөө арлын Долоон болдог, Туулын Хар Түнэ  
 B. Хэрлэний Хөдөө арлын Долоон болдог, Тамирын Шар орд  
 C. Хэрлэний Хөдөө арлын Долоон болдог, Шилхинцэг  
 D. Хархорум хот, Туулын Хар Түнэ  
 E. Хархорум хот, Хар зүрхэний Хөх нуур
20. Хубилай хаан Юань гүрний засаг захиргааны зохион байгуулалтыг өөрчлөн зохион байгуулахдаа үндэс болгосон “Төр байгуулах санал” хэмээх бичгийг хэн зохиосон бэ? (2 оноо)
- A. Зүрчид түшмэл Елюй Чуцай  
 B. Хятад түшмэл Хао Цзин  
 C. Хятад түшмэл Жоа Бин  
 D. Монгол жанжин Баян  
 E. Түвэд лам Пагва
21. Монголын эзэнт гүрний үед холбогдох “Судрын чуулган” хэмээх зохиолыг бичсэн хүн аль нь вэ? (1 оноо)
- A. Plano Карпини  
 B. Гилиом Рубрук  
 C. Марко Поло  
 D. Рашид-Ад-Дин  
 E. Ибн-Аль-Асир
22. Монголын Юань гүрэн хэдээс, хэдэн оны хооронд оршин тогтнож байсан бэ? (1 оноо)
- A. 1206 - 1260 он  
 B. 1260 - 1368 он  
 C. 1242 - 1368 он  
 D. 1256 - 1402 он  
 E. 1225 - 1402 он
23. Дундад Азийн Хорезмын Шахт улсыг Монголчууд хэрхэн нэрийдэж байсан бэ? (1 оноо)
- A. Тангуд улс  
 B. Сартуул улс  
 C. Хар Хятан улс  
 D. Алтан улс  
 E. Өмнөд Сүн улс
24. 1369-1370 онд Хятадын эрдэмтэн Сүн Лян, Ван Вэй нар тэргүүлэн зохиосон бөгөөд “Уг тэмдэглэл” 47 бүлэг, “Ойллого дэвтэр” 58 бүлэг, “Айлтгал тэмдэглэл” 8 бүлэг, “Шастир” 97 бүлэг, нийт 210 бүлэгтэй түүхийн зохиол аль нь вэ? (2 оноо)
- A. “Монголын нууц товчоо”  
 B. “Алтан дэвтэр”  
 C. “Юань улсын судар”  
 D. “Цагаан түүх”  
 E. “Зүрхэн тольт”
25. 1399 онд Ойрадын Үгэчи Хашиха, Батула Чинсан нар Монголын хэн гэдэг хааныг хороосноор Зүүн Монголын ноёд бутран салахад хужир нэмсэн хэмээн түүхэнд бичсэн бэ? (2 оноо)
- A. Аюушридара Билэгт хаан  
 B. Төгстөмөр Усгал хаан  
 C. Энх Зоригт хаан  
 D. Элбэг Нигүүсэгч хаан  
 E. Өлзийт Төмөр хаан
26. Мандуул хааны бага хатан Мандухай Монголын томоохон ноёдын дэмжлэгтэйгээр Батмөнхийг долоон настайд нь хаан ширээнд өргөмжилсөн нь дараах учиртай. Зөв хариултыг сонгоно уу? (2 оноо)
- A. Бага настай хүүхдийн нэрээр төрийн эрхийг барих оролдлого  
 B. Чингис хааны алтан ургийн шууд угсааны хүн Батмөнх л байсан  
 C. Мандуул хаан Батмөнхийг хаан ширээнд суулгахыг гэрээсэлсэн  
 D. Ойрадын ноёд Батмөнхийг хүлээн зөвшөөрсөн  
 E. Түвэдийн Далай лам зөвлөсөн

27. 1538 онд Боди-Алаг хаан Баруун гурван түмний ноёдын хамтаар Урианхай түмэнд довтлон буулган авч улмаар Урианхай түмнийг тараан бусад таван түмэнд нэгтгэсэн хамгийн гол шалтгаан аль нь вэ? (2 оноо)  
 А. Хүн ам нь цөөхөн болж нэгэн түмний хэмжээнд хүрэхгүй болсон учир  
 В. Урианхайг захирч байсан ноёд нь харь гаралтай байсан учир  
 С. Урианхайн түмэн урвалга гаргаж их хаанд захирагдахгүй болсон учир  
 D. Газар нутаг нь үржил шимтэй учир  
 E. Таван ханы засаг байгуулах болсон учир хүчээр тараасан
28. Дараах түүхэн сурвалжуудын алийг нь Саган сэцэн 1662 онд зохиосон бэ? (1 оноо)  
 А. “Алтан товч”  
 В. “Эрдэнийн эрих”  
 С. “Шар тууж”  
 D. “Эрдэнийн товч”  
 E. “Гангын урсгал”
29. Дараах түүхэн үйл явдлыг он дарааллын дагуу зөв эрэмбэд оруулна уу? (2 оноо)  
 1. Баруун Монгол Манжид эзлэгдэв  
 2. Өмнөд Монгол Манжид эзлэгдэв  
 3. Умард Монгол Манжид эзлэгдэв  
 4. Хөх нуурын Монголчууд Манжийг дагав  
 А. 1, 2, 3, 4  
 В. 4, 3, 2, 1  
 С. 2, 4, 1, 3  
 D. 2, 3, 4, 1  
 E. 3, 1, 4, 2
30. 1639 онд Халхын Сэцэн хан Шолой тэргүүтэй Халхын язгууртнууд Түшээт хан Гомбодоржийн хөвгүүн Занабазарыг Монголын бурхан шашны тэргүүнд өргөмжилсөн чуулган хаана болсон бэ? (1 оноо)  
 А. Ширээт цагаан нуур  
 В. Тарвагатайн Улаан бураа  
 С. Заг, Байдрагийн Хүрэн бэлчир  
 D. Ар Элстэй  
 E. Долоннуур
31. Галдан бошготын дараа Зүүнгарын хаан ширээнд хэн суусан бэ? (1 оноо)  
 А. Цэвээнравдан хаан  
 В. Галданцэрэн хаан  
 С. Цэвээндоржнамжил хаан  
 D. Ламдаржаа хаан  
 E. Даваач хаан
32. Түүхэн сурвалжид бичсэнээр, “... Хойд зүгийн шар Хятад (Орос) хэмээх улсын хааны төр амгалан, их улс боловч шажин эс дэлгэрсэн бөгөөд бас ч хувцасны зах буруу тул үл болмуй. Өмнө зүгийн хар Хятад (Манж) хэмээх улсын хааны төр төвшин амгалан сайны дээр бас түүнд бурхны шашин дэлгэрсэн ... их буянтай хаан мөний тул тэр зүг явбаас төр тогтож, хамаг амьтан жаргамуй” хэмээн хэдэн оны ямар чуулган дээр хэн хэлсэн бэ? (2 оноо)  
 А. 1639 оны Ширээт цагаан нуурын чуулган дээр Сэцэн хан Шолой хэлсэн  
 В. 1640 оны Тарвагатайн чуулган дээр Засагт хан Субадай хэлсэн  
 С. 1686 оны Хүрэн бэлчирийн чуулган дээр Түшээт хан Чахундорж хэлсэн  
 D. 1689 оны Ар элстэйн чуулган дээр Өндөр гэгээн Занабазар хэлсэн  
 E. 1691 оны Долоннуурын чуулган дээр Энх-Амгалан хаан хэлсэн
33. Манж Чин гүрний эсрэг тэмцэж байсан дараах зүтгэлтнүүдийн хэн нь Бээжинд хүргэгдэн есөн зоосны нүхээр сүвлүүлж алуулсан бэ? (1 оноо)  
 А. Халхын Цогт тайж  
 В. Цахарын Лигдэн хаан  
 С. Хойдын ноён Амарсанаа  
 D. Хотогойдын ван Чингүнжав  
 E. Зүүнгарын хаан Галдан бошгот
34. Монголын шашны тэргүүн II Богдод зориулан бариулсан хийд аль нь вэ? (1 оноо)  
 А. Амарбаясгалант  
 В. Дашчойлон  
 С. Дамбадаржаалин  
 D. Манзушир  
 E. Эрдэнэ зуу
35. 1911 онд Богд хаант Монгол улсын шүүх яамны сайдаар хэн томилогдсон бэ? (1 оноо)  
 А. Да лам Цэрэнчимэд  
 В. Түшээ гүн Чагдаржав  
 С. Эрдэнэ ван Намсрай  
 D. Хошой чин ван Ханддорж  
 E. Засаг гүн Гомбосүрэн

36. 1912 оны III сард батлагдсан Дундад Иргэн улсын үндсэн хуульд Монголын тусгаар тогтнолын талаар ямар заалт орсон бэ? (2 оноо)  
 А. “Ар, Өвөр Монгол, Түвэд, Хөх нуур нь нь ДИУ-ын бүрэлдэхүүн биш”  
 В. “Ар, Өвөр Монгол, Түвэд, Хөх нуур нь ДИУ-ын бүрэлдэхүүн мөн”  
 С. “Ар ба Өвөр Монгол нь ДИУ-ын бүрэлдэхүүн хэсэг мөн бусад нь биш”  
 D. “Түвэд, Хөх нуур нь ДИУ-ын бүрэлдэхүүн хэсэг мөн Ар ба Өвөр Монгол биш”  
 E. “Ар ба Өвөр Монгол, Хөх нуур нь ДИУ-ын бүрэлдэхүүн хэсэг мөн Түвэд биш”
37. 1912 онд байгуулагдсан Богд Хаант Монгол улсын цэргийн сургууль Нийслэл хүрээний аль хэсэгт оршиж байсан бэ? (1 оноо)  
 А. Баруун хүрээ  
 В. Усны гудамж  
 С. Хужирбулан  
 D. Консулын дэнж  
 E. Зүүн хүрээ
38. Богд хаант Монгол улсын Ерөнхий сайд Т.Намнансүрэн Хаант Орос улсад байхдаа Монгол төрийн дээд шагнал одон хийлгэсэн бөгөөд тэрхүү одон ямар нэртэй байсан бэ? (1 оноо)  
 А. “Эрдэнийн очир” одон  
 В. “Цэргийн гавьяаны улаан тугийн” одон  
 С. “Бичгийн гавьяаны улаан тугийн” одон  
 D. “Алтан гадас” одон  
 E. “Чингис хаан” одон
39. Богд хаант Монгол улсын үеийн Улсын дээд, доод хурал хэдэн онд байгуулагдсан бэ? (1 оноо)  
 А. 1911 он  
 В. 1912 он  
 С. 1913 он  
 D. 1914 он  
 E. 1915 он
40. 1915 онд Хиагтад болсон Монгол - Орос - Хятад гурван улсын гэрээгээр тухайн цагийн Монгол улсын хил хязгаарт дараах бүс нутгийн алийг нь багтана хэмээн заасан бэ? (2 оноо)  
 А. Халхын дөрвөн аймаг, Хөх нуур  
 В. Халхын дөрвөн аймаг, Ховдын хязгаар  
 С. Халхын дөрвөн аймаг, Өвөр Монгол  
 D. Халхын дөрвөн аймаг, Халимаг Монгол  
 E. Халхын дөрвөн аймаг, Буриад Монгол
41. 1918-1919 онд С.Данзан, Д.Сүхбаатар, Д.Догсом нарын тэргүүлэн байгуулсан нууц бүлгэм Нийслэл хүрээний аль хэсэгт байгуулагдаж байсан бэ? (1 оноо)  
 А. Баруун хүрээ  
 В. Усны гудамж  
 С. Хужирбулан  
 D. Консулын дэнж  
 E. Зүүн хүрээ
42. 1919 онд Хятадын гэмн цэргийн эрхтнүүд Монголын автономыг устгах үед Ерөнхий сайдаар хэн ажиллаж байсан бэ? (1 оноо)  
 А. Сайн ноён хан Намнансүрэн  
 В. Шанзодба да Бадамдорж  
 С. Жалханз хутагт Дамдинбазар  
 D. Манзушир хутагт Цэрэндорж  
 E. Жүн ван Ширмэндамдин
43. “Монголын нэг өдөр” хэмээх алдарт бүтээлийг туурвисан, Монголын шинэ үеийн дүрслэх урлагийн төлөөлөгч, нэртэй зураач аль нь вэ? (1 оноо)  
 А. Г.Дорж  
 В. Б.Шарав  
 С. М.Парчин  
 D. Д.Бодоо  
 E. Ш.Дамдин
44. Дараах зүтгэлтнүүдийн хэн нь Монголын эдийн засгийг өөд нь татахын тулд хувийн аж ахуйтныг дэмжих хэрэгтэй хэмээн үзэж улмаар “Баяжихтун” хэмээх уриа гарган баруунтан хэмээгдэн цаазлуулсан бэ? (1 оноо)  
 А. Д.Бодоо  
 В. С.Данзан  
 С. С.Дамдинбазар  
 D. Б.Цэрэндорж  
 E. А.Амар
45. 1931 оны Засаг захиргааны зохион байгуулалтаар 13 аймгийг шинээр байгуулсан бөгөөд дараах аймгуудын аль нь 1931 онд байгуулагдсан бэ? (1 оноо)  
 А. Булган  
 В. Сэлэнгэ  
 С. Дундговь  
 D. Сүхбаатар  
 E. Тариалан



46. 1932 оны зэвсэгт бослого аль аймгийн, аль сумын нутгаас эхэлсэн хэмээн түүхэнд бичсэн байдаг вэ? (1 оноо)  
 А. Архангай аймгийн Цэцэрлэг сум  
 В. Хөвсгөл аймгийн Рашаант сум  
 С. Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сум  
 D. Архангай аймгийн Идэр сум  
 E. Төв аймгийн Лүн сум
47. Дараах үндсэн хуулиудын аль нь “Чойбалсангийн үндсэн хууль” хэмээн түүхэнд үлдсэн бэ? (2 оноо)  
 А. 1924 оны анхдугаар үндсэн хууль  
 В. 1940 оны үндсэн хууль  
 С. 1960 оны үндсэн хууль  
 D. 1992 оны үндсэн хууль  
 E. 1940 болон 1960 оны үндсэн хууль
48. БНМАУ милитарист Японд хэдэн оны хэдэн сарын хэдний өдөр дайн зарласан бэ? (2 оноо)  
 А. 1945 оны VIII сарын 8  
 В. 1945 оны VIII сарын 9  
 С. 1945 оны VIII сарын 10  
 D. 1945 оны IX сарын 10  
 E. 1946 оны I сарын 8
49. 1956 оны XII сард хуралдсан МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооноос “Сэхээтний төөрөгдөл” хэмээхийг хэрхэн тодорхойлсон бэ? (1 оноо)  
 А. Сэхээтний шүүмжлэлт уур амьсгалыг  
 В. Сэхээтний хэлний боловсролыг  
 С. Сэхээтний биеэ тоосон байдлыг  
 D. Сэхээтний тоо хэт олширч байгааг  
 E. Хөдөө мал маллах хүнгүй болж байгааг
50. Манай улс НҮБ-д элсэх өргөдлөө хэдэн онд анх гаргаж, хэдэн онд элссэн бэ? (2 оноо)  
 А. 1946 онд анх өргөдөл гаргаж, мөн ондоо элссэн  
 В. 1946 онд анх өргөдөл гаргаж, 1951 онд элссэн  
 С. 1946 онд анх өргөдөл гаргаж, 1961 онд элссэн  
 D. 1961 онд анх өргөдөл гаргаж, мөн ондоо элссэн  
 E. 1961 онд анх өргөдөл гаргаж, 1971 онд элссэн
51. “БНМАУ-ын хөдөлмөрийн баатар” цол, тэмдгийг хамгийн анх түрүүн хүртсэн, малчин баатар хэн бэ? (1 оноо)  
 А. Ямаачин баатар Т.Жамц  
 В. Хоньчин баатар З.Очир  
 С. Хоньчин баатар С.Цогтгэрэл  
 D. Саальчин баатар С.Хандсүрэн  
 E. Тэмээчин баатар Т.Бумбаа
52. “Хэнтийн өндөр ууланд” хэмээх хийлийн гоцлолыг хэн нь бичсэн бэ? (1 оноо)  
 А. Ж.Чулуун  
 В. Н.Жанцанноров  
 С. Б.Дамдинсүрэн  
 D. С.Гончигсумлаа  
 E. Г.Бирваа
53. 1980-1990-ээд оны зааг үеийн Монгол орны байдлыг тодорхойлоход хамааралгүй зүйл өгүүлсэн бол аль нь вэ? (2 оноо)  
 А. Захиран тушаах систем ноёрхож байсан  
 В. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг ноёрхож байсан  
 С. Өмчийн олон хэлбэр, түүний дотор хувийн өмчийг үгүйсгэсэн  
 D. Нэг үзэл суртлын ноёрхол тогтсон  
 E. Олон намын тогтолцоо бий болсон
54. 1990 оны “Улс төрийн өлсгөлөн”-г зогсоож, “Дугуй ширээ”-ний ярилцлагын үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлэл хийж байсан, улс төрийн тулхтай зүтгэлтэн аль нь вэ? (1 оноо)  
 А. Д.Бямбасүрэн  
 В. Ж.Батмөнх  
 С. П.Очирбат  
 D. Г.Очирбат  
 E. Ш.Гунгаадорж

55. Мөнгөний ханшийг хоёр дахин бууруулж, түүнтэй уялдан цалин хөлс болон жижиглэн худалдаалах бараа таваарын үнийг хоёр дахин нэмэгдүүлэх арга хэмжээ авсан гэвэл энэ хэдээс хэдэн оны хооронд, хэний тэргүүлж байсан Засгийн газрын үед авсан арга хэмжээ вэ? (2 оноо)
- A. 1990-1992 онд Д.Бямбасүрэнгийн тэргүүлсэн засгийн газар
  - B. 1992-1996 онд П.Жасрайн тэргүүлсэн засгийн газар
  - C. 1996-1998 онд М.Энхсайханы тэргүүлсэн засгийн газар
  - D. 2000-2004 онд Н.Энхбаярын тэргүүлсэн засгийн газар
  - E. 2004-2006 онд Ц.Элбэгдоржийн тэргүүлсэн засгийн газар
56. 1992 онд Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалтанд тодорхой өөрчлөлт оруулан, шинээр 3 аймгийг байгуулсан билээ. Дараах аймгуудын аль нь 1992 онд байгуулагдсан бэ? (1 оноо)
- A. Архангай аймаг
  - B. Булган аймаг
  - C. Сэлэнгэ аймаг
  - D. Говь-Сүмбэр аймаг
  - E. Сүхбаатар аймаг

### ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ, ДАРААЛАЛ СЭРГЭЭХ ДААЛГАВАР

#### Санамж:

- a. Даалгаврын хариуг зөв тогтоож харгалзуулах, дараалал сэргээх байдлаар гүйцэтгэнэ үү?
- b. Зөв хариулт бүр нэг оноотой.

- 2.1. Доор өгүүлсэн түүхэн үйл явдлыг он цагийн хувьд зөв дарааллаар нь эрэмбэлнэ үү? (5 оноо)
- a. Түрэгийн хожуу үеийн хаант улс байгуулагдав
  - b. Жужаны үндсэн хүн ам нь Түрэгийн захиргаанд оржээ
  - c. Хятаны “Их бичиг”-ийг Лубугу, Тулюйбу нар зохиожээ
  - d. Модун Хүннүгийн шаньюй болсон
  - e. Уйгур улс Монгол нутагт төвлөрөн засаглаж эхэлжээ
- 2.2. Чингис хааны байгуулсан Их Монгол улсын төрд зүтгэж байсан хүмүүсийг албан тушаалтай нь тохируулна уу? (5 оноо)
- 1. Төрийн их заргач
  - 2. Төрийн бэхи
  - 3. Ван буюу ерөнхий сайд
  - 4. Мал аж ахуйн сайд
  - 5. Төрийн заарин
  - a. Шихихутаг
  - b. Үсүн өвгөн
  - c. Гоо Мухулай
  - d. Тодой чэрби
  - e. Хөхөчү
- 2.3. Улс төрийн бутралын үеийн хаадыг төр барьж байсан он цагтай нь тохируулна уу? (5 оноо)
- 1. Буяншир хаан
  - 2. Эсэн хаан
  - 3. Молон хаан
  - 4. Батмөнх Даян хаан
  - 5. Түмэн Засагт хаан
  - a. 1480-1517 он
  - b. 1453-1454 он
  - c. 1408-1412 он
  - d. 1465-1466 он
  - e. 1558-1592 он
- 2.4. XX зууны монголын сонин хэвлэлийг анх хэвлэгдэн гарсан он цагтай нь зөв харгалзуулна уу? (5 оноо)
- 1. “Монголын үнэн”
  - 2. “Нийслэл хүрээний сонин бичиг”
  - 3. “Монгол үгийн бодрол”
  - 4. “Намын амьдрал”
  - 5. “Үг”
  - a. 1990
  - b. 1960
  - c. 1908
  - d. 1920
  - e. 1915